

## “Монгол-Оросын харилцаан дахь “Зөөлөн хүч”” хамтарсан нэг сэдэвт бүтээл



2022 онд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаач А.Нямдолжин, Н.Ариунгуа, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвд, Будда судлалын хүрээлэн болон Доржи Банзаровын нэрэмжит Буриадын Улсын Их Сургуулийн эрдэмтэн судлаач В.А.Родионов, Л.В.Курас, И.Г.Актамов, И.Ц.Доржиева, Э.В.Цыремпилова, А.В.Комбаев нар “Монгол-Оросын харилцаан дахь “Зөөлөн хүч” хамтын нэг сэдэвт бүтээл хэвлэгдэн гарч олны хүртээл боллоо. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн сан, ОХУ-ын Суурь судалгааны сангийн дэмжлэгээр 2019-2022 онд хэрэгжүүлсэн “Монгол-Оросын харилцаан дахь “Зөөлөн хүч: харьцуулсан дүн шинжилгээ” хамтарсан төслийн хүрээнд бичигдсэн энэхүү бүтээл нь: Удиртгал. 1. “Орос-Монголын харилцаан дахь “Зөөлөн хүч”: түүх судлал ба өөрчлөлт. 2. Монгол дахь Оросын “Зөөлөн хүч”:

уламжлал, өнөөгийн байдал, хэтийн төлөв. 3. “Монголын “Зөөлөн хүч”: дэлхий болон бүс нутгийн хэмжүүр гэсэн 3 бүлэг 12 зүйлээс бүрджээ.

““Орос-Монголын харилцаан дахь “Зөөлөн хүч”: түүх судлал ба өөрчлөлт” хэмээх нэгдүгээр бүлэгт Л.В.Курас, Н.Ариунгуа, А.Нямдолжин нар хоёр улсын харилцаан дахь зөөлөн хүчний талаар судлагдсан байдалд дүн шинжилгээ хийсний зэрэгцээ “зөөлөн хүчний бодлого” хэмээх ойлголтонд оршиж буй улс төр, геополитикийн агуулгыг нээн харуулж, тус ойлголтын утга санаанд гарч буй зарим нэгэн өөрчлөлт, мөн чанарыг дурдан улс хоорондын харилцаанд үзүүлэх эерэг нөлөө, боломжийг Монгол-Оросын боловсрол, соёлын салбар дахь хамтын ажиллагаа, Монгол дахь их гүрнүүдийн “зөөлөн хүч”-ний нөлөө болоод Монгол Улсын хувьд олон улсын тавцанд эзлэх жин нөлөөгөө нэмэгдүүлэх, үндэстний онцлог, ялгарах давуу талыг бусдад таниулах, улмаар гадны хөрөнгө оруулагчдыг өөртөө татах замаар эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэсэн эерэгээр татах, нөлөөлөх, зөөлөн хүчний бодлогыг үзэл баримтлалын түвшинд боловсруулан хэрэгжүүлэх нөөц боломж байна хэмээн үзсэн байна.

“Монгол дахь Оросын “Зөөлөн хүч”: уламжлал, өнөөгийн байдал, хэтийн төлөв” хэмээх хоёрдугаар бүлэгт В.А.Родионов, А.Нямдолжин, И.Ц.Доржиева, Э.В.Цыремпилова,

И.Г.Актамов нар Оросын Монгол дахь “зөөлөн хүч”-ний нөөц боломж болох Оросын Монгол дахь ЭСЯ, Орос ордон буюу Оросын ШУСТ, “Орос ертөнц” санг дурдсан боловч эдгээр байгууллагуудын Монголын нийгэмд нөлөөлөх нөлөөллийн хүрээ өнгөрсөн Зөвлөлтийн үетэй харьцуулахад ихээхэн хумигдсан, Монгол-Оросын харилцаан дахь “зөөлөн хүч”-ний бодлого хэрэгжиж ирсэн боловсрол, соёл болон аялал жуулчлалын салбарын үүрэг нөлөө чухал ач холбогдолтой болох талаар өгүүлсэн байна.

“Монгол Улс дахь “зөөлөн хүч”-ийн дэлхийн болон бүс нутгийн хэмжүүр” хэмээх гуравдугаар бүлэгт Монгол Улс “зөөлөн хүч”-ний бодлогыг хэрэгжүүлэгч субъектын талаас авч үзсэн ба эхний хоёр хэсэгт Монгол Улсын гадаад бодлогын үндсэн чиглэлүүдэд тулгуурлан дэлхийн болон бүс нутгийн тавцанд энх тайвныг эрхэмлэгч, ардчилсан орны хувьд “эвлэрүүлэн зуучлах дипломат

ажиллагаа”-гаар дамжуулан байр сууриа илэрхийлж ирсэн туршлагыг судлан дүгнэжээ.

Энэхүү хамтын бүтээл нь Монгол-Оросын харилцааны түүхэн уламжлал дээр тулгуурлан орчин үеийн хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг “зөөлөн хүч”-ний үзэл баримтлалын үүднээс тайлбарлан 1990 оноос ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш Монгол Улсад Хятад, АНУ, Япон, Өмнөд Солонгос зэрэг орнуудын “зөөлөн хүч”-ний бодлого соёл урлаг, боловсрол, ажил, хэргийн харилцаа нөлөөллийн хэлбэрээр дамжин хэрхэн хэрэгжиж байгааг Монгол дахь Оросын “зөөлөн хүчний бодлого”-той харьцуулан судалсны сацуу, хоёр орны харилцааны өргөн агуулгыг нээн харуулсан тал бүрийн дүн шинжилгээ, үнэлэлт дүгнэлт, эрдэм шинжилгээний онолын түвшинд боловсруулсан судалгааны чухал ач холбогдолтой бүтээл болжээ.

*Мэдээ бэлтгэсэн:  
А.Нямдолжин,  
доктор (Ph.D)*